

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: : СНАГ-2025/004/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Монгол Улсын Ерөнхий аудиторын Орлогч,
тэргүүлэх аудитор: Я.Самбууня
Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn
Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Энхбаатар
Утас: 261885 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Мөнхчимэг
Утас: 261740 Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn
Аудитор: Ч.Мөнхбулган
Утас: 261740 Цахим хаяг: munkhbulganch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД С.ОДОНТУЯА
ТАНАА

2025.04.23 № 1827
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 9,880.2 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Тухайлбал:

- Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 2,564.9 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрсэн;
- Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, бүрэн хэрэгжүүлээгүй, Цэвэр агаар сангийн эх үүсвэрээр 2019-2021 онд хэрэгжиж дууссан 7,315.3 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх ажлыг шийдвэрлээгүйгээс Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны санхүүгийн тайлангийн дуусаагүй барилга, байгууламж дансанд бүртгэлтэй зөрчил байна.

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.10 6 дугаар зүйлийн 6.4.1, 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.2.5 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 83.9 сая модыг шууд болон дүйцүүлэх хэлбэрээр тарьсан бөгөөд 2024 онд 9.5 сая модыг тарьж, арчилгаа, хамгаалалтын ажлыг гүйцэтгэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаагчаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Байгаль орчинд ээлтэй, ногоон тодотголтой 20 гаруй төрлийн бүтээгдэхүүн худалдан авахад зориулж иргэд, аж ахуйн нэгжид олгох хөнгөлөлттэй зээлийн хүүг санхүүжүүлэхээр Төрийн банк болон Хас банкттай 800.0 сая төгрөгийн гэрээг шинэчлэн байгуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж хүргүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

 Д.ЗАГДЖАВ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	145,875,963.0	161,481,495.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	38,549,722.8	53,230,248.9
33	АВЛАГА	3,558,978.2	2,418,586.6
34	УРЬДЧИЛГАА	26,008,868.7	19,096,000.5
35	БАРАА МАТЕРИАЛ	25,842,746.6	30,614,830.8
36	НӨӨЦИЙН БАРАА	37,827.4	30,708.3
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	51,877,819.5	56,091,120.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	105,771,746.4	122,427,445.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	105,771,746.4	122,427,445.9
39100	Газар	-	132,825.0
39200	Биет хөрөнгө	85,507,597.3	101,398,774.4
39300	Биет бус хөрөнгө	20,264,149.1	20,895,846.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	251,647,709.5	283,908,941.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	38,011,266.8	57,402,110.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	38,011,266.8	57,402,110.7
41300	Өглөг	36,590,809.6	49,124,612.7
41400	Урьдчилж орсон орлого	1,420,457.2	8,277,498.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	213,636,442.7	226,506,830.4
51	Засгийн газрын хувь оролцоо	213,636,442.7	226,506,830.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	44,398,032.0	45,249,731.4
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	7,910,927.9	7,910,927.9
51200	Хуримтлагдсан үр дүн	157,788,422.2	169,643,851.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,539,060.6	3,702,319.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	251,647,709.5	283,908,941.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	217,826,122.9	290,726,977.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	72,111,132.7	38,230,239.8
120	Нийтлэг татварын бус орлого	70,248,017.4	35,146,508.4
122	Тусламжийн орлого	1,863,115.3	3,083,731.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	145,714,990.2	252,496,738.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	147,593,346.3	234,988,717.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	145,903,457.9	234,988,717.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	127,750,856.0	206,836,905.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,096,003.8	97,798,766.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,693,083.2	12,225,044.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,272,640.9	2,352,793.2
2104	Хангамж, бараа материалын зардал	3,913,667.6	3,848,017.4
2105	Норматив зардал	910,025.0	320,425.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,175,723.2	1,837,546.4
2107	Томилолт, зочны зардал	1,185,030.0	1,873,674.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,042,060.2	71,845,606.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,462,622.2	14,735,031.2
212	ТАТААС	-	45,017.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,152,601.9	28,106,794.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,689,888.4	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	70,232,776.6	55,738,260.3
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,226.5	10,617.1

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	43,267,656.8	44,067,641.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	26,967,346.4	11,681,236.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	185,913,387.0	-	185,913,387.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(237,573.5)	-	(237,573.5)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	185,675,813.6	-	185,675,813.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	652,833.5	-	652,833.5
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	344,609.7	-	344,609.7
6	Зарласан ногдол ашиг	(4,160.4)	-	(4,160.4)
7	Тайлант үеийн үр дүн	26,967,346.4	-	26,967,346.4
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	213,636,442.7	-	213,636,442.7
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	973,919.6	-	973,919.6
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	214,610,362.3	-	214,610,362.3
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	152,153.2	-	152,153.2
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	87,248.0	-	87,248.0
13	Зарласан ногдол ашиг	(24,169.4)	-	(24,169.4)
14	Тайлант үеийн үр дүн	11,681,236.3	-	11,681,236.3
15	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	226,506,830.4	-	226,506,830.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	167,363,264.2	283,090,555.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,584,628.5	28,358,051.8
120	Нийтлэг татварын бус орлого	21,046,939.7	24,020,893.0
122	Тусламжийн орлого	537,688.9	4,337,158.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	145,778,635.7	254,732,503.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	149,291,352.6	238,466,661.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	149,291,352.6	238,466,661.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	129,318,410.2	209,249,144.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,196,335.5	97,879,982.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,874,620.3	12,373,373.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,369,258.6	2,383,404.7
2104	Хангамж, бараа материалын зардал	2,494,767.9	2,955,369.6
2105	Норматив зардал	223,299.5	219,531.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,251,526.8	3,835,126.0
2107	Томилолт, зочны зардал	962,611.4	1,765,607.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,218,749.3	87,090,793.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,727,241.0	745,955.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,972,942.4	29,217,516.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	18,071,911.6	44,623,893.9

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	7,869.3	8,002.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	9,585,624.8	29,676,213.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,585,624.8	29,676,213.1
2200	Дотоод эх үүсвэрээр	9,585,624.8	29,676,213.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(9,577,755.5)	(29,668,210.8)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(131,280.3)	(275,157.0)
14	Бусад эх үүсвэр	326.5	9,066.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	131,606.8	284,223.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	8,362,875.8	14,680,526.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	30,186,847.0	38,549,722.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38,549,722.8	53,230,248.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	240,267,212,500.00	224,357,036,476.63	15,910,176,023.37	93.4
УРСГАЛ ЗАРДАЛ	219,729,532,500.00	205,967,216,838.96	13,762,315,661.04	93.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	214,737,472,200.00	201,612,128,899.43	13,125,343,300.57	93.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,563,055,200.00	94,510,864,163.77	4,052,191,036.23	95.9
Үндсэн цалин	50,309,458,000.00	49,343,865,386.48	965,592,613.52	98.1
Нэмэгдэл	29,416,334,000.00	27,391,197,137.29	2,025,136,862.71	93.1
Унаа хоолны хөнгөлөлт	12,049,491,800.00	11,449,353,921.65	600,137,878.35	95.0
Урамшуулал	6,462,158,100.00	6,166,106,466.08	296,051,633.92	95.4
Гэрээт ажлын хөлс	325,613,300.00	160,341,252.27	165,272,047.73	49.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,198,895,200.00	11,834,666,563.30	1,364,228,636.70	89.7
Тэтгэврийн даатгал	8,908,083,800.00	8,230,615,257.99	677,468,542.01	92.4
Тэтгэмжийн даатгал	1,072,602,000.00	925,430,993.90	147,171,006.10	86.3
ҮОМШӨ-ний даатгал	536,791,900.00	462,309,471.15	74,482,428.85	86.1
Ажилгүйдлийн даатгал	536,211,900.00	438,427,504.71	97,784,395.29	81.8
Эрүүл мэндийн даатгал	2,145,205,600.00	1,777,883,335.55	367,322,264.45	82.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,380,092,600.00	2,281,272,823.79	98,819,776.21	95.8
Гэрэл, цахилгаан	852,641,000.00	812,848,068.52	39,792,931.48	95.3
Түлш, халаалт	1,086,168,700.00	1,055,451,898.03	30,716,801.97	97.2
Цэвэр, бохир ус	135,125,800.00	116,915,129.70	18,210,670.30	86.5
Байрны түрээс	306,157,100.00	296,057,727.54	10,099,372.46	96.7
Хангамж, бараа материалын зардал	2,270,822,300.00	2,194,914,428.89	75,907,871.11	96.7
Бичиг хэрэг	202,347,600.00	201,845,694.00	501,906.00	99.8
Тээвэр, шатахуун	1,538,779,500.00	1,481,246,864.39	57,532,635.61	96.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	297,371,900.00	281,722,359.50	15,649,540.50	94.7
Ном, хэвлэл	10,277,600.00	10,263,950.00	13,650.00	99.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,218,900.00	24,256,350.00	962,550.00	96.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	196,826,800.00	195,579,211.00	1,247,589.00	99.4
Норматив зардал	130,966,900.00	125,910,870.00	5,056,030.00	96.1

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,315,900.00	52,277,950.00	37,950.00	99.9
Хоол, хүнс	890,400.00	890,400.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	77,760,600.00	72,742,520.00	5,018,080.00	93.5
Эд хогшил, урсгал засварын зардал	6,825,875,600.00	6,518,504,467.88	307,371,132.12	95.5
Багаж, техник, хэрэгсэл	5,371,566,100.00	5,073,486,145.28	298,079,954.72	94.5
Тавилга	49,225,200.00	49,225,180.00	20.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	56,539,800.00	55,478,050.00	1,061,750.00	98.1
Урсгал засвар	1,348,544,500.00	1,340,315,092.60	8,229,407.40	99.4
Томилолт, зочны зардал	1,244,323,300.00	1,201,219,314.60	43,103,985.40	96.5
Дотоод албан томилолт	1,244,323,300.00	1,201,219,314.60	43,103,985.40	96.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,146,121,500.00	82,474,389,047.40	6,671,732,452.60	92.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,511,314,600.00	81,879,435,211.40	6,631,879,388.60	92.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	47,181,700.00	33,858,665.90	13,323,034.10	71.8
Даатгалын үйлчилгээ	62,144,300.00	54,614,156.26	7,530,143.74	87.9
Тээврийн хэрэгслийн татвар	37,304,800.00	28,282,460.84	9,022,339.16	75.8
Тээврийн хэрэгслийн оношилгоо	16,071,200.00	12,857,682.00	3,213,518.00	80.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	321,205,500.00	317,956,630.00	3,248,870.00	99.0
Газрын төлбөр	109,402,500.00	106,097,887.00	3,304,613.00	97.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	585,800.00	554,900.00	30,900.00	94.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	40,911,100.00	40,731,454.00	179,646.00	99.6
Бараа үйлчилгээний бусад зардал	977,319,600.00	470,387,219.80	506,932,380.20	48.1
Бараа үйлчилгээний бусад зардал	668,152,500.00	162,703,033.80	505,449,466.20	24.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	309,167,100.00	307,684,186.00	1,482,914.00	99.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,992,060,300.00	4,355,087,939.53	636,972,360.47	87.2
Засгийн газрын урсгал шилжүүлэг	401,699,100.00	247,350,414.00	154,348,686.00	61.6
Засгийн газрын гадаад шилжүүлэг	401,699,100.00	247,350,414.00	154,348,686.00	61.6
Бусад урсгал шилжүүлэг	4,590,361,200.00	4,107,737,525.53	482,623,674.47	89.5
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	202,262,000.00	193,674,900.00	8,587,100.00	95.8
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	97,933,000.00	86,050,000.00	11,883,000.00	87.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,275,075,200.00	1,887,063,393.73	388,011,806.27	82.9

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,004,970,800.00	1,930,928,117.80	74,042,682.20	96.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,120,200.00	10,021,114.00	99,086.00	99.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,537,680,000.00	18,389,819,637.67	2,147,860,362.33	89.5
Барилга байгууламж	7,984,380,000.00	6,734,626,127.85	1,249,753,872.15	84.3
Их засвар	3,000,000,000.00	2,868,992,247.82	131,007,752.18	95.6
Тоног төхөөрөмж	9,553,300,000.00	8,786,201,262.00	767,098,738.00	92.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	240,267,212,500.00	228,225,611,247.99	12,041,601,252.01	95.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	238,781,746,700.00	222,225,468,030.33	16,556,278,669.67	93.1
Улсын төсвөөс санхүүжих	238,781,746,700.00	222,225,468,030.33	16,556,278,669.67	93.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,485,465,800.00	6,000,143,217.66	(4,514,677,417.66)	403.9
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,448,820,600.00	5,904,591,555.23	(4,455,770,955.23)	407.5
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	36,645,200.00	95,551,662.43	(58,906,462.43)	260.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	35,328,844,355.20	(35,328,844,355.20)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	46,893,320,747.35	(46,893,320,747.35)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	6454	5567	887	86.3
БАЙГУУЛЛАГЫН ТОО	86	86	0	100.0
Төсвийн байгууллага	86	86	0	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	3184	2741	444	86.1
Удирдах ажилтан	146	93	53	63.7
Гүйцэтгэх ажилтан	2683	2360.5	322.5	88.0
Үйлчлэх ажилтан	355	283	72	79.7
Гэрээт ажилтан	0	4	-4	
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	3184	2741	444	86.1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		23,080,293,268.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ		19,668,303,983.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		8,317,031,808.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,745,646,455.52
210101	Үндсэн цалин		447,309,842.38
210102	Нэмэгдэл		1,838,705,694.17
210104	Урамшуулал		459,630,918.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		332,507,158.87
210201	Тэтгэврийн даатгал		277,237,268.67
210202	Тэтгэмжийн даатгал		13,365,582.92
210203	ҮОМШӨ-ний даатгал		10,579,866.14
210204	Ажилгүйдлийн даатгал		4,821,593.25
210205	Эрүүл мэндийн даатгал		26,502,847.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		48,854,102.00
210301	Гэрэл, цахилгаан		8,266,978.00
210302	Түлш, халаалт		16,267,124.00
210303	Цэвэр, бохир ус		3,610,000.00
210304	Байрны түрээс		20,710,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		581,266,509.08
210401	Бичиг хэрэг		94,623,384.00
210402	Тээвэр, шатахуун		325,058,737.75
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		26,404,331.33
210404	Ном, хэвлэл		6,720,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		26,735,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		101,725,056.00
2105	Норматив зардал		93,621,070.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		66,678,380.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		26,942,690.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,119,375,493.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		587,928,654.00
210602	Тавилга		109,757,471.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		13,371,890.00
210604	Урсгал засвар		408,317,478.00
2107	Томилолт, зочны зардал		564,388,155.00
210701	Гадаад албан томилолт		80,261,993.00
210702	Дотоод албан томилолт		484,126,162.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,539,293,844.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,520,700,247.97
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,532,600.00
210803	Даатгалын үйлчилгээ		9,134,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		406,046.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		240,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		879,400.00
210807	Газрын төлбөр		6,400,601.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		292,079,020.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		148,212,755.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		143,866,265.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		11,351,272,175.10
2132	Бусад урсгал шилжүүлэг		3,319,393,245.97
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		1,233,266,055.97
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		328,000.00

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		7,280,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,078,519,190.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		8,031,878,929.13
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		8,031,878,929.13
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		3,411,989,285.00
2200	Дотоод эх үүсвэрээр		3,411,989,285.00
220001	Барилга байгууламж		907,119,500.00
222001	Тоног төхөөрөмж		1,804,412,290.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		700,457,495.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		23,022,281,343.54
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		23,022,281,343.54
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		11,131,899,566.95
131103	ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,724,495,136.31
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,641,654,910.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		6,524,231,729.73

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,945.1 сая төгрөгийн 73 алдаа илэрснээс аудитын явцад 6,932.5 сая төгрөгийн 72 алдааг залруулж, 12.6 сая төгрөгийн 1 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Аудитаар нийт 11,415.8 сая төгрөгийн 93 зөрчил¹ илэрснээс, 220.7 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 10,377.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 44 албан шаардлага хүргүүлж, 806.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 36 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 4 албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 11,415.8 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшин 1,475.9 сая төгрөгөөс өндөр тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөв.

3.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 98 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 56 байгууллагад дүгнэлт гаргаж, 42 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж аудитыг гүйцэтгэсэн. Бие даан дүгнэлт гаргасан 44 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 11 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Татгалзсан санал” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 6,945.1 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 6,932.5 сая төгрөгийн 72 алдааг залруулж, 12.6 сая төгрөгийн 1 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар 2,564.9 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 220.7 сая төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт тогтоож, 1,527.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 39 албан шаардлага хүргүүлж, 806.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 36 зөвлөмж өгч, 10.9 сая төгрөгийн хариуцлага тооцуулах 3 албан шаардлага хүргүүлсэн байна.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Аудитаар нийт 8,850.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 8,850.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

3.2.1 Албан шаардлага

1. “Аймгуудад орчны бохирдлыг бууруулах” төсөл, арга хэмжээний санхүүжилтээр 2019 оноос 2021 оны хооронд гүйцэтгэсэн дулааны цахилгаан станцын шүүлтүүр суурилуулах, аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулах барих, лаг шатаах үйлдвэр барих, төвийн дулааны шугам сүлжээний ажил, хийн халаагуур нийлүүлэх, нийт 7,315.4 сая төгрөгийн гэрээт ажил дууссан боловч хөрөнгийг эзэмшигч, ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй хэвээр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг эзэмшигч, ашиглагч байгууллагад шилжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Засгийн газрын 2015 оны “Аялал жуулчлалын үндэсний төв” ТӨААТҮГ-ыг татан буулгах тухай 310 дугаар, 2022 оны “Монгол ус” ТӨААТҮГ-ыг татан буулгах тухай 243 дугаар, 2024 оны “Аялал жуулчлалын хөгжлийн төв”-ийг татан буулгах тухай 36 дугаар тогтоолуудыг

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэрэгжүүлээгүй, аж ахуйн нэгж байгууллагыг татан буулгаагүй, хаалтын баланс гаргаагүй, нийт 238.9 сая төгрөгийн цэвэр хөрөнгийг санхүүгийн тайланд нэгтгэсэн байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6-д “хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон өөрийн шийдвэрийн биелэлтийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид шалган танилцаж, биелэлтийг нь бүрэн хангах талаар шуурхай даалгавар өгч гүйцэтгүүлнэ” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын тогтоолоор татан буугдсан байгууллагуудын хаалтын баланс гаргаж данс бүртгэлээс хасаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Бусад эргэлтийн хөрөнгө дансанд 2012 онд бүртгэсэн 11,541.4 сая төгрөгийн цэвэр агаар сангийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилт хяналт тавих, хүрэх үд дүнг хангаж ажиллах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг эзэмшигч, ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,296.6 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, аудитаар илэрсэн зөрчлийг 20.0 хувиар бууруулах албан шаардлага хүргүүлэв.

5. Урьдчилж гарсан зардлын дансанд 2012 оноос 2022 оны хооронд хуримтлуулан бүртгэсэн ажлуудын тооцоог хянаж баталгаажуулан, үлдэгдлийг бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж тус тус заасантай нийцэхгүй, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасан үндэслэл бүрдсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн урьдчилж гарсан зардал дансны тооцоог хянаж, баталгаажуулан үлдэгдлийг бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй ахлах нягтлан

бодогч Ж.Туяацэцэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлэв.

6. "Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв" ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төрийн аудитын байгууллагаас "Дүгнэлт өгөхөөс татгалзсан" байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42.2-т "Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасан үндэслэл бүрдсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн аудитаар татгалзсан дүгнэлт авсан "Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв" ТӨААТҮГ-ын захирал Х.Ерхулан, ахлах нягтлан бодогч Ж.Жавзандулам нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлэв.

3.3 Түүврийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн, алдаа зөрчил

1. Богдхан уулын дархан цаазат газрын захиргаа

Төлбөрийн акт

Илрүүлэлт: Тус Хамгаалалтын захиргааны даргын 2024 оны А/56 дугаар тушаалаар "Байгууллагын шилдэг" 5 албан хаагчдад олгосон мөнгөн урамшууллаас 0.3 сая төгрөгийн Хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй бүрэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шууд бус орлогод нийт дүнгээр тооцно", 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна", 25 дугаар зүйлийн 25.1.1-д "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шагнал, урамшууллын зардлаас хувь хүний орлогын албан татвар суутгаж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

Илрүүлэлт: Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 986.5 сая төгрөгийн 18 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:", 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаанд орлогын гүйлгээг иж бүрэн мэдээлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт: Төсвийн захирагч нь хуульд заасан шаардлагын хүрээнд жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэлгүйгээр 4 хуулийн этгээдтэй 42.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр

зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөөгүй, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа

Төлбөрийн акт

Илрүүлэлт: Тайлант онд 0.3 сая төгрөгийн автомашины торгуулийн төлбөрийг тээврийн хэрэгслийн татварын зардлаас шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөр тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Автомашины торгуулийн төлбөрт төлсөн дүнг буруутай албан тушаалтнаар төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

Илрүүлэлт: Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлгүй Ниссан Патрол 97-68 УБЧ улсын дугаартай тээврийн хэрэгслийг үйл ажиллагаандаа ашиглаж, засварын зардалд 12.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн 12(а)-д "Үндсэн хөрөнгө гэдэг нь ... түрээслэхээр эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж буй байгууллагын эзэмшиж байгаа ..." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгөд бүртгэлгүй тээврийн хэрэгслийг үйл ажиллагаандаа ашигласан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт: Төсвийн захирагч нь хуульд заасан шаардлагын хүрээнд жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэлгүйгээр 4 хуулийн этгээдтэй 77.4 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөөгүй, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй нийт 64.5 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, дансны үнийг шинэчлэн тогтоох ажлыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т *"илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох"*, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 7 дугаар зүйлийн 7.1-д *"Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж, шийдвэрлүүлнэ"* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, дансны үнийг шинэчлэн тогтоох ажлыг хэрэгжүүлэх.

Илрүүлэлт: Төсөв захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын баталсан тушаалын хавсралт, маягт аргачлалын дагуу иж бүрэн толилуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3-т *"Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах"*, 54 дүгээр зүйлийн 54.5-д *"Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"*, 54.6-д *"Энэ хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу төсөвт зохицуулалт хийсэн тохиолдолд хөтөлбөрийн гүйцэтгэлийг анх төлөвлөсөн хүрэх үр дүнгийн зорилттой нь харьцуулсан байдлаар тайлагнана"* гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуульд заасны дагуу санхүүгийн тайланг иж бүрэн бэлтгэж байх.

Илрүүлэлт: Тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 765.3 сая төгрөгийн 13 гүйлгээ, зарлагын 5.0 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д *"Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:"*, 4.1.1-д *"мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"*, 4.1.3-т *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"*, 6.4-т *"Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ"*, 6.4.4-т *"таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"*, 6.4.5-д *"цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"* гэж заасантай тус тус нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаандаа орлого, зарлагын гүйлгээг иж бүрэн мэдээлэх.

3. Туул голын сав газрын захиргаа

Албан шаардлага

Илрүүлэлт: "Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усыг биотехнологийн аргаар цэвэрлэх" төслийг хэрэгжүүлэх ажлыг "Ховд Тул" ХХК-тай шууд гэрээ байгуулж, гэрээний дагуу 548.8 сая төгрөгийг 2019 онд шилжүүлж урьдчилгаа дансанд бүртгэсэн боловч гэрээний үүргийн биелэлтийг хангуулаагүй, ажлыг хүлээн аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т *"төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"*, 20.2.6-д *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Он дамнасан урьдчилгаа дансанд бүртгэлтэй ажлыг гэрээний дагуу гүйцэтгүүлж, хүлээн аваагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Илрүүлэлт: Төсөв захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын баталсан тушаалын хавсралт, маягт аргачлалын дагуу иж бүрэн толилуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3-т "Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", 54 дүгээр зүйлийн 54.5-д "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна", 54.6-д "Энэ хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу төсөвт зохицуулалт хийсэн тохиолдолд хөтөлбөрийн гүйцэтгэлийг анх төлөвлөсөн хүрэх үр дүнгийн зорилттой нь харьцуулсан байдлаар тайлагнана" заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуульд заасны дагуу санхүүгийн тайланг иж бүрэн бэлтгэх.

Илрүүлэлт: Тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 84.4 сая төгрөгийн 2 гүйлгээг илүү мэдээлж, зарлагын 160.0 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:", 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаандаа орлого, зарлагын гүйлгээг иж бүрэн мэдээлэх.

4. Хан Хэнтий улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа

Илрүүлэлт: Санхүүгийн байдлын тайлангийн 1.0 сая төгрөгийн үнэлгээтэй 10 морийг бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн, Аж ахуйн материалын дансанд 12.6 сая төгрөгийн 22 бүл зөгийг дансны ангилал зөрүүлэн бүртгэл хөтлөлтөд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх" заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг холбогдох СТОУС-ын дагуу үнэн, зөв ангилж бүртгэх.

Төлбөрийн акт

Илрүүлэлт: Тус Хамгаалалтын захиргааны даргын 2024 оны А/49 дугаар тушаалаар идэвхтэн байгаль хамгаалагчдад олгосон мөнгөн урамшуулал болон хамгаалалтын захиргааны ажилчдын дундах тэмцээний шагналын нийт дүнгээс 0.7 сая төгрөгийн Хувь хүний орлогын албан татварыг суутгалгүй бүрэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна:", 7.1.1-д "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар

тооцож, албан татвар ногдуулна”, 25 дугаар зүйлийн 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шагнал, урамшууллын зардлаас хувь хүний орлогын албан татвар суутгаж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

Илрүүлэлт: Тайлант онд байгууллагын шинэ жилийн баяраар 1.7 сая төгрөгийн аяны хэрэгсэл, будаа агшаагч, тоос сорогч гэх мэт бараа материалыг ажилчдад бэлэглэж, оны эцэст актлах хөрөнгүүдийн жагсаалтаар акталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй худалдан авалт хийж, бэлэглэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт: Төсвийн захирагч нь хуульд заасан шаардлагын хүрээнд жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэлгүйгээр 3 хуулийн этгээдээс 60.9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, 44.3-т “Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөөгүй худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Илрүүлэлт: Тайлант онд байгууллагын үйл ажиллагааны чиглэлд хамааралгүй БОУАӨЯ-ны мэдээ мэдээллийг 8 хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан 71.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын чиг үүрэгт хамааралгүй ажил гүйлгээг санхүүжүүлэхгүй байх.

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй нийт 46.2 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, дансны үнийг шинэчлэн тогтоох ажлыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь

эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж, шийдвэрлүүлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, дансны үнийг шинэчлэн тогтоох ажлыг хэрэгжүүлэх.

Илрүүлэлт: Тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 20.0 сая төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 51.4 сая төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй, 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай тус тус нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаандаа орлого, зарлагын гүйлгээг иж бүрэн мэдээлэх.

5. Цэнгэг ус, байгаль хамгаалах төв УТҮГ

Төлбөрийн акт

Илрүүлэлт: Тайлант онд 0.3 сая төгрөгийг согтууруулах ундаа, ороолт зэрэг бэлэг дурсгалын зүйл худалдан авч зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бэлэг дурсгалын зардлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт: Тус газрын захирлын 2024 оны А/54 дугаар тушаалаар ХАКАТОН - 2024 уралдааны шагнал болон менторын урамшуулалд олгосон нийт дүнгээс 0.8 сая төгрөгийн Хувь хүний орлогын албан татварыг суутгалгүй бүрэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна”, 7.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 21 дүгээр зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна”, 25 дугаар зүйлийн 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шагнал, урамшууллын зардлаас хувь хүний орлогын албан татвар суутгаж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд оны эцэст ажилчидтай холбоотой нийт 11.9 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй нийт 464.4 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, дансны үнийг шинэчлэн тогтоох ажлыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж, шийдвэрлүүлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, дансны үнийг шинэчлэн тогтоох ажлыг хэрэгжүүлэх.

Илрүүлэлт: Тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 933.2 сая төгрөгийн 17 гүйлгээг мэдээлээгүй, 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай тус тус нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаандаа орлого, зарлагын гүйлгээг иж бүрэн мэдээлэх.

Илрүүлэлт: Тус байгууллага ажилтнуудад ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхгүйгээр сар бүр өөрчилж, шинээр тушаал гарган олгож байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын “... төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 8.7-д “Албан хаагчийн

ажлын үр дүн, мэргэжлийн ур чадварыг үнэлсний үндсэн дээр үр дүнгийн урамшуулал болон ур чадварын нэмэгдэл олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх.

6. Байгаль орчны судалгаа шинжилгээний төв

Албан шаардлага

Илрүүлэлт: Өмнөх аудитаар тус байгууллагын ХУД-ийн 23-р хороонд байрлалтай 16,880 мкв газар өөрийн эзэмшилд байхгүй зөрчилд өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах", Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Иргэн, хуулийн этгээд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8.1.1-д заасан эрхийг хуульд заасан журмын дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр өмчлөх эрх үүснэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн байгууллагын эзэмшилд бүртгүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийцлийн асуудалтай холбоотой 8,214.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4,786.1 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага, 2,033.9 сая төгрөгийн зөрчилд 16 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд эхний хагас жилийн санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт зэрэг 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх, мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 6,566.6 сая төгрөгийн 8 зөрчил илэрч, 3,702.3 сая төгрөгийн 3 албан шаардлага, 2,864.4 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн байна.

4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох БМ201667054 төсөл"-өөс үнэ төлбөргүй шилжүүлсэн 1,087.7 сая төгрөгийн 16 машин тоног төхөөрөмж, тээврийн

хэрэгслийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцэн хүлээн авсан боловч хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т “Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1-д “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл хөтөлбөрөөс хүлээн авсан машин тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслийг хөрөнгийн дансанд бүртгээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллага	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ											
1	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	1	1,351.2			1	1,351.2	1	1,351.2		
2	Архангай аймгийн УЦУОШТ	1	6.4		-	1	6.4	1	6.4		
3	Баянхонгор УЦУОШТ	1	8.3		-	1	8.3	1	8.3		
4	Говь-Алтай аймгийн УЦУОШТ	2	169.6	1	161.6	1	8.1	2	169.6		
5	Говь-Сүмбэр аймгийн УЦУОШТ	6	59.3	1	2.4	5	56.9	6	59.3		
6	Дорнод УЦУОШТ	1	146.7		-	1	146.7	1	146.7		
7	Дорноговь аймгийн УЦУОШТ	3	761.2		-	3	761.2	3	761.2		
8	Дундговь аймгийн ЦУОШГ	3	79.2	2	49.7	1	29.5	3	79.2		
9	Орхон аймгийн УЦУОШТ	1	0.3		-	1	0.3	1	0.3		
10	Өмнөговь аймгийн УЦУОШТ	4	111.4	2	101.4	2	9.9	4	111.4		
11	Сэлэнгэ аймгийн УЦУОШТ	2	1.0		-	2	1.0	2	1.0		
12	Хөвсгөл аймгийн УЦУОШТ	2	4.7			2	4.7	2	4.7		
13	Ховд аймгийн УЦУОШТ	2	1.2			2	1.2	2	1.2		
14	Богдхан уулын дархан цаазат газрын захиргаа	2	15.3			2	15.3	2	15.3		
15	Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	4	100.7			4	100.7	4	100.7		
16	Туул голын сав газрын захиргаа	4	162.4			4	162.4	4	162.4		
17	Хан Хэнтий улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	7	542.8			7	542.8	6	530.2	1	12.6
18	Цэнгэг ус, байгаль хамгаалах төв УТҮГ	6	1,016.9			6	1,016.9	6	1,016.9		
19	Байгаль орчны судалгаа шинжилгээний төв	2	77.3			2	77.3	2	77.3		
20	Ойн газар	7	1,878.5			7	1,878.5	7	1,878.5		
21	Усны газар	2	384.3			2	384.3	2	384.3		
22	Алтайн өвөр говийн сав газрын захиргаа	5	24.1			5	24.1	5	24.1		
23	Дархан цаазат газрын Дорнод хамгаалалтын захиргаа	2	5.5			2	5.5	2	5.5		
24	Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газрын захиргаа	1	19.3			1	19.3	1	19.3		
	Дүн	71	6,927.7	6	315.1	65	6,612.5	70	6,915.0	1	12.6
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН											
1	Байгаль орчин, уур амьсгалын сан	2	17.4	1	14.2	1	3.2	2	17.4		
	Дүн	2	17.4	1	14.2	1	3.2	2	17.4		

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Нийт дүн	73	6,945.1	7	329.3	66	6,615.8	72	6,932.5	1	12.6
-----------------	-----------	----------------	----------	--------------	-----------	----------------	-----------	----------------	----------	-------------

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ											
1	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	6	8,850.9			5	8,850.9			1	-
	Дүн	6	8,850.9			5	8,850.9			1	-
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ											
1	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	7	420.1			4	367.0	3	53.1		
2	Архангай аймгийн ЦУОШТ	4	7.7			4	7.7		-		
3	Булган аймгийн ЦУОШТ	2	1.5				-	2	1.5		
4	Баянхонгор аймгийн ЦУОШТ	1	9.4				-	1	9.4		
5	Баян-өлгий аймгийн ЦУОШТ	1	4.1			1	4.1				
6	Говь-сүмбэр аймгийн ЦУОШТ	1	2.1					1	2.1		
7	Дорнод аймгийн ЦУОШТ	6	7.5			2		3	7.5	1	
8	Дундговь аймгийн ЦУОШТ	2	10.7			1	1.4		-	1	9.2
9	Орхон аймгийн ЦУОШТ	2	13.6				-	1	12.0	1	1.6
10	Сэлэнгэ аймгийн ЦУОШТ	1	8.9			1	8.9		-		
11	Ховд аймгийн ЦУОШТ	1	3.0				-	1	3.0		
12	Хөвсгөл аймгийн ЦУОШТ	5	2.2			1		4	2.2		
13	Өвөрхангай аймгийн ЦУОШТ	1	3.7			1	3.7		-		
14	Өмнөговь аймгийн ЦУОШТ	7	3.6				-	7	3.6		
15	Богдхан уулын дархан цаазат газрын захиргаа	2	42.3	1	0.3	1	42.0				
16	Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	5	154.8	1	0.3	2	90.0	2	64.5		
17	Туул голын сав газрын захиргаа	5	64.5			3		2	64.5		
18	Хан Хэнтий улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	3	63.3	1	0.7	2	62.6				
19	Цэнгэг ус, байгаль хамгаалах төв УТҮГ	5	477.4	1	0.3	2	12.7	2	464.4		
20	Байгаль орчны судалгаа шинжилгээний төв	1	-			1	-				
21	Ойн газар	9	688.4	1	205.7	6	399.2	2	83.5		
22	Усны газар	6	451.4	1	4.6	4	446.8	1			

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

23	Хэнтий аймгийн Гутайн даваа-Хөмүүл голын эхийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	1	0.2	1	0.2						
24	Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргаа	1	3.4	1	3.4						
25	Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газрын захиргаа	2	11.3	1	5.2			1	6.1		
	Дүн	81	2,455.1	9	220.7	36	1,446.2	33	777.4	3	10.9
ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН											
1	Байгаль орчин, уур амьсгалын сан	6	109.8			3	80.8	3	29.0		
	Дүн	6	109.8			3	80.8	3	29.0		
	Нийт Дүн	93	11,415.8	9	220.7	44	10,377.9	36	806.4	4	10.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
1	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	2	1,087.7			1	1,087.7	1	-		
2	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	1	-			1	-				
3	Цаг уур, орчны шинжилгээний газар	1	793.4			1	793.4				
4	Өмнөговь УЦУОШТ	1	3,293.3			1	3,293.3				
5	Ховд УЦУОШТ	1	-					1	-		
6	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн	1	-					1	-		
7	Богдхан уулын дархан цаазат газрын захиргаа	1	986.5			1	986.5				
8	Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	1	770.3					1	770.3		
9	Туул голын сав газрын захиргаа	1	244.4					1	244.4		
10	Хан Хэнтий улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	3	189.2					3	189.2		
11	Цэнгэг ус, байгаль хамгаалах төв УТҮГ	1	933.2					1	933.2		
12	Ойн газар	1	269.2			1	269.2				
13	Усны газар	1	14.6					1	14.6		
14	Байгаль орчин, уур амьсгалын сан	1	207.3			1	207.3				
15	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл /ХБНГУ тусламж/-2 үе шат	1	1,394.7							1	1,394.7
16	Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргаа	3	14.9			3	14.9				
17	Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газрын захиргаа	3	-					3	-		
18	Дархан цаазат газрын Дорнод хамгаалалтын захиргаа	2	10.2			2	10.2				
	Дүн	26	10,208.9			12	6,662.5	13	2,151.7	1	1,394.7
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
19	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	2	-			1	-	1	-		
20	Ойн газар	4	-			2	-	2	-		
21	Байгаль орчин, уур амьсгалын сан	1	29.8			1	29.8				

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

22	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл /ХБНГУ тусламж/-2 үе шат	1	-					1	-		
23	Дархан цаазат газрын Дорнод хамгаалалтын захиргаа	1	-					1	-		
	Дүн	9	29.8			4	29.8	5	-		
	Нийт дүн	35	10,238.7			16	6,692.3	18	2,151.7	1	1,394.7